



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 2/44

Хэрлэн сум

“Эрхэт Монгол медиа групп” ХХК-тай хамтран
ажиллахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн иргэдийг цаг үеийн мэдээ, мэдээллээр хангах, нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг иргэдэд сурталчлах зорилгоор “Эрхэт Монгол медиа групп” ХХК-тай гэрээний дагуу хамтран ажиллахад 15,000,000 (арван таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

